

2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 5-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ  
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	"Хоггүй Өлгий" нийтийн их цэвэрлэгээний ажлыг цаашид улам эрчимжүүлж,байгууллагууд жилийн туршид хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллах	7 хоног	Аймгийн МХГ-ын дарга	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй “Хоггүй Өлгий” хөтөлбөрийн хүрээнд Мэргэжлийн хяналтын газраас санаачлан “Өлгий хотын ариун цэвэр, орчны эрүүл ахуйн нөхцөлийг хангуулах” сарын аяныг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Өлгий сумын Засаг даргын Тамгын газартай хамтарч зохион байгууллаа.</p> <p>Сарын аяны хүрээнд Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 04/147 удирдамжаар 6 ажлын хэсэг 18 улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр аймгийн хэмжээний нийт 218 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулж, 107 байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, 111 зөрчил илрүүлэн 89 зөрчлийг газар дээр нь арилгуулж, шалгалтын явцад 98 заалт бүхий 18 албан шаардлага үйлдэж, илэрсэн зөрчлийг үндэслэн 1 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 500.000, 10 хүнд 500.000 төгрөгний шийтгэл ногдууллаа.</p> <p>Шалгалтын явцад 45 машин хог ачуулж, 2860 м2 талбайг цэвэрлүүлж, 211 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 10 цэгт эзэнгүй хог илрүүлж ачуулах арга хэмжээ авлаа.</p> <p>Мөн 250 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийлгэсэн. Өлгий сумын Засаг даргын Тамгын газарт Засаг даргын өрөөнд мах нядалгааны үйлдвэрүүдээс гарч буй хог хаягдлыг устган зайлуулах газрын асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар удирдлагуудтай хамтарч хурал хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p>
2	Facebook буюу цахим орчноор худал мэдээ, мэдээлэл цацаж ард иргэд, үндэстний хооронд талцал, хуваагдал үүсгэж буй нэр бүхий хүмүүсийг холбогдох мэргэжлийн байгууллага илрүүлэн хариуцлага тооцож, цаашид уг явдлыг хязгаарлах арга хэмжээ авч хэрэгжилтийг Шуурхай хуралд танилцуулах	7 хоног	Аймгийн ЦГ-ын даргад	

3	“ЭЕШ-2019” хоёр сарын аяны хүрээнд мэргэжлийн байгууллага эцэг эхчүүд, хүүхдүүдийн идэвх чармайлтыг нэмэгдүүлэн Монгол хэл болон бусад хичээлүүдийн шалгалтад онцгой анхаарч сурагчдыг бэлтгэх	7 хоног	Аймгийн БСУГ-ын даргад	
4	Аймгийн төвд шилийг цуглуулах 2 цэгийг АРУ ХХК-тай хамтран байгуулах болсон тул байрлалыг тодорхойлж, газрыг бэлдэх асуудлыг шийдвэрлэх	7 хоног	Өлгий сумын Засаг даргад	
5	Байгууллагууд улс, аймгийн хэмжээнд явагдаж буй аяны арга хэмжээнүүдэд идэвх санаачилгатай оролцож, биелэлтийг хангуулан ажилласан талаар тогтмол мэдээлж байх	7 хоног	Бүх байгууллагын дарга нарт	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019”, “Эрүүл аюулгүй орчин-таны оролцоо” “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аянуудын хүрээнд сургалт, хэлэцүүлэг зохион байгуулж, аянуудын хүрээнд хяналт шалгалт хийж аяны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг тогтмол хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллаж байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

7 ХОНОГИЙН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

№	Хийж хэрэгжүүлсэн ажил	Дараа долоо хоногт хийж хэрэгжүүлэх ажил
1	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019”, “Эрүүл аюулгүй орчин-таны оролцоо” “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аяны хүрээнд Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн нийт ажилтнуудад сарын аяны зорилго, ач холбогдлыг танилцуулж, аюулгүй орчин, гэрэлт ирээдүй сэдэвт зургийн уралдаан, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” чиглэлээр илтгэлийн уралдаануудад багш сурагчдыг идэвхтэй хамруулахыг уриалж, хөдөлмөрийн харилцаа, аюулгүй байдлын сургалт зохион байгууллаа.	
2	Алтанцөгц сумд зохион явуулсан “Тариалагчдын зөвлөгөөн”-д оролцож “Дотоод хяналт”, “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгох журам” сэдэвт сургалтыг зохион явуулж ажиллав.	
3	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоол, БСШУС Сайдын А/648 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2018 оны А/827 тоот захирамж, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 01/12 тоот удирдамжийн хүрээнд аймгийн Музей, Цэнгэл, Сагсай, Улаанхус сумдын орон нутаг судлах танхимд байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, түүх, соёлын хөдлөх дурсгалын улсын тооллогын салбар комиссын бүрэлдэхүүнтэй хамт улсын тооллогын үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр 6 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан	
4	НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ ЭЭЛЖИТ ТӨЛӨВЛӨГӨӨТ ШАЛГАЛТЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ. 2019 оны төлөвлөгөөт тусгагдсаны дагуу Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 04/ 131 удирдамжаар эмчилгээ, эм, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт төлөвлөгөөт төлөвлөгөөт шалгалтыг эхлүүлж, Нэгдсэн эмнэлгийн мэс засал, чих хамар хоолой, шүдний кабинет, амбулаторийн боолтын хэсэг, ариутгалын тасаг, хоолны газраас 18 агаарын сорьц, 200 орчны эд юмс болон ариутгасан багаж хэрэгслээс арчдасын шинжилгээ авч нян судлалын лабораторид шинжилгээнд хамааруулсан.Шалгалт үргэлжилж байна.	
5	Сагсай сумын нутаг дэвсгэрт орших, Бугат сумын төвөөс 3 км орчим ойрхон газарт малын гаралтай хог хаягдал хаясан асуудлын талаар Мэргэжлийн хяналтын газрын зүгээс Зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа явуулж, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөрчил арилгуулах эрх бүхий албан тушаалтны хугацаат албан даалгавар хүргүүлсэн билээ. Уг даалгаврын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Сагсай сумын нутаг дэвсгэрт малын гаралтай хог хаягдал хаясан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч байгаа талаар орон нутгийн Саян телевизээр мэдээлэл хийв.	
6	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019”, “Эрүүл аюулгүй орчин-таны оролцоо” “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аянуудын зорилго, аяны хугацаанд хийгдэх ажлын талаар телевизэд мэдээлэл өгөв.	
7	"Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт" сарын аяны хүрээнд удирдах ажилтны зөвлөгөөнд оролцон Байгаль орчны багц хуулиар мэдээлэл өгч ажилласан.	
8	Мэргэжлийн Хяналтын Газрын Экспорт, Импорт, Хил Хорио Цээрийн Хяналтын Хэлтсийн эхний улиралд Цагааннуур боомт дээр хийгдсэн хяналт шалгалт мөн улсын хил дээр гарч байгаа зөрчил, зөрчлийн шалтгаан, нөхцөл байдал, худалдаа эрхлэгчид болон иргэд амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, хориглосон, хязгаарласан бараа, бүтээгдэхүүн импортлохгүй байх,	

	импортолж буй хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, сав баглаа, боодол, хаяг шошгод бичигдсэн мэдээлэл, бусад анхаарах зүйлсийн талаар мэдээлэл хийлээ.	
9	“Эрүүл аюулгүй орчин-Таны оролцоо” сарын аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Ш.Серикбол, Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч М.Азамат нар нь газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 31 хүнд Шатахуун түгээх станц, Галын аюулгүйн норм” /БНБД 21-07-14/ барилгын норм ба дүрэм, 5.13 кодтой Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, Улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн дэлгэрэнгүй жагсаалт, Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин. Техникийн шаардлага MNS 0217:2017, Дизелийн түлш. Евро. Техникийн шаардлага MNS 0216:2017, Шатахуун түгээгүүр. Шалгах арга хэрэгсэл MNS 3015:2014 улсын стандарт болон 5.28.1 кодтой Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хяналтын хуудсаар сургалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.	
10	Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй “Хоггүй Өлгий” хөтөлбөрийн хүрээнд Мэргэжлийн хяналтын газраас санаачлан “Өлгий хотын ариун цэвэр, орчны эрүүл ахуйн нөхцөлийг хангуулах” сарын аяныг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Өлгий сумын Засаг даргын Тамгын газартай хамтарч зохион байгууллаа.  Сарын аяны хүрээнд Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 04/147 удирдамжаар 6 ажлын хэсэг 18 улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр аймгийн хэмжээний нийт 218 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулж, 107 байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, 111 зөрчил илрүүлэн 89 зөрчлийг газар дээр нь арилгуулж, шалгалтын явцад 98 заалт бүхий 18 албан шаардлага үйлдэж, илэрсэн зөрчлийг үндэслэн 1 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 500.000, 10 хүнд 500.000 төгрөгний шийтгэл ногдууллаа.  Шалгалтын явцад 45 машин хог ачуулж, 2860 м2 талбайг цэвэрлүүлж, 211 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 10 цэгт эзэнгүй хог илрүүлж ачуулах арга хэмжээ авлаа.  Мөн 250 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийлгэсэн. Өлгий сумын Засаг даргын Тамгын газарт Засаг даргын өрөөнд мах нядалгааны үйлдвэрүүдээс гарч буй хог хаягдлыг устган зайлуулах газрын асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар удирдлагуудтай хамтарч хурал хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	
11	“Эрүүл аюулгүй орчин-Таны оролцоо” сарын аяны төлөвлөгөөний дагуу “Шударга худалдааг хөгжүүлэх, буруу хэмжлийн улмаас хэрэглэгчдэд учирч болзошгүй эдийн засгийн хохирлоос урьдчилан сэргийлэхэд иргэн таны хяналт, оролцоо” сэдвээр Рысжан ХХК-ны Өлгий сумын 4 дүгээр ШТС-д аймгийн Стандарт, хэмжилзүйн хэстсийн улсын шалгагч Х.Өмирбекээр Шатахуун түгээгүүр. Шалгах арга хэрэгсэл MNS 3015:2014 улсын стандартын дагуу шатахуун түгээгүүрийг шалгаж нийт 40-өөд хүнийг оролцуулан үзүүлэх сургалт зохион байгуулан ажиллалаа.	
12	Амьтны тухай хуульд зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Хадран овгийн Хариус загасыг, 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл алтайн сугас загасыг агнахыг хориглосон үржлийн хугацаанд загас агнахгүй байх, загас агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөр болох хариус загасны ширхэг тутамд 10000 төгрөг, алтайн сугас загасны ширхэг тутамд 14000 төгрөгийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 300000 төгрөг, хуулийн этгээдийг гурван мянган нэгж буюу 3000000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хариуцлага хүлээлгэх талаар, мөн худалдсан, худалдан авсан бол дээрх арга хэмжээг загас агнасанатай адилтган үзэж хариуцлага тооцох талаар болон загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур хэрэглэх, ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх, гол мөрөнд бүх төрлийн завиар загасчлах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, аймгийн хэмжээний агнуурын бүс нутгуудаас ахуйн хэрэгцээний зориулалтаар загас агнах хуваарийг БОНХАЖЯамнаас батлаагүй тул энэ онд огт загас агнаж болохгүй талаар ярилцлага өгөв.	

<p>Мөн тусгай хамгаалалттай газар нутгаас зөвшөөрөлгүй ан амьтан, загас агнасан тохиолдолд Эрүүгийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр болсон тухай сануулав.</p> <p>Галуу, нугас болон ус, намгийн бусад агнуурын шувууг жил бүрийн 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл агнахгүй байх талаар анхааруулав.</p>	
---	--